



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/160

Хэрлэн сум

Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
үйл ажиллагаанд “Олон улсын чанарын менежментийн  
тогтолцооны MNS ISO 9001:2016, ISO18091:2020  
стандарт” нэвтрүүлэхэд хөрөнгө зарцуулах

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны аравдугаар хуралдааны “Аймгийн 2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд “Олон улсын чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016, ISO18091:2020 стандарт” нэвтрүүлэх зардалд зориулан 19.500.000 (арван есөн сая таван зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010449